

БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН  
ДАРГА.....С.АРИУНБОЛД

ОГНОО:.....



## НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

АЖ АХУЙ ХАНГАМЖ, АРИУТГАЛ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ МАТЕРИАЛ ХУДАЛДАН  
АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

Аж ахуй хангамж, ариутгал цэвэрлэгээний материал  
худалдан авах тендер

HTTT/202401004

Улаанбаатар хот  
2024.02.14

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ) .....	1
1. Тендерийн цар хүрээ .....	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг .....	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж .....	1
4. Сонирхогч этгээд, оролцогч .....	2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ .....	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл .....	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг .....	3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах .....	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт .....	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл .....	4
11. Тендерийн иж бүрдэл .....	4
12. Тендерийн жишиг маягтууд .....	5
13. Хувилбарт санал .....	5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг .....	5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг .....	6
16. Чадавхын болон туршлагын шаардлага .....	7
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт .....	8
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт .....	9
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт .....	9
20. Тендерийн валют .....	10
21. Тендер хүчинтэй байх хугацаа .....	10
22. Тендерийн баталгаа .....	10
23. Тендер баталгаажуулах, илгээх .....	10
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа .....	11
25. Тендерийн талаар тодруулга авах .....	11
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх .....	11
27. Тендерийг үнэлэх .....	11
28. Арифметик алдааг запруулах .....	11
29. Оролцогчид давуу эрх олгох .....	12
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт .....	12
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох .....	12
32. Тендерийг эрэмбэлэх .....	12
33. Оролцогчийн чадавхыг дахин магадлах .....	12
34. Мэдэгдэл хүргүүлэх .....	12
35. Гүйцэтгэлийн баталгаа .....	13
36. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах .....	13

# I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

## A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн хүрээ	цар	1.1.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг		1.2.	Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж		1.3.	Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.
4. Худалдан авах ажиллагааны цахим систем		1.4.	Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.
5. Авлига, сонирхлын зөрчлөөс байх	ашиг ангид	2.1.	Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
		3.1.	Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
		4.1.	Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> ) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
		5.1.	Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

- 5.2. Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч этгээд, оролцогч**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

**Б.АГУУЛГА**

- 9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**
- 9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
- I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
  - II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
  - III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
  - IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
  - V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
  - VI Бүлэг. Гэрээний нөхцөл.
- 9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
- 10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**
- 10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.
- 10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.
- 10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.
- 11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.
- 11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

- 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.
- 13. Тендерийн бүрдэл**
- иж 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
- 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
- 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
- 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
- 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

- 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
- 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
- 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
- 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.
- 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн жишиг маягтууд**
- 15. Хувилбарт санал**
- 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг**
- 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
- 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
- 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
- 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
- 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

- 16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**
- 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
- 17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.
- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.

- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.
- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын туршлагын шаардлага**
- болов**
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.

**19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**

- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендert ирүүлнэ.
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендert ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 24. Тендерийн баталгаа**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээнээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

<b>31. Давуу эрх олгох</b>	31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно. 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй. 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
<b>32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт</b>	32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
<b>33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох</b>	33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална. 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ. 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
<b>34. Тендерийг эрэмбэлэх</b>	34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
<b>35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах</b>	35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална. 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ. 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
<b>Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>36. Шийдвэр хүргүүлэх</b>	36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

- 37. Гүйцэтгэлийн баталгаа**
- 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**
- 38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

<b>ТШЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагч: <b>Нийслэлийн түргэн тусlamжийн төв</b>
<b>ТШЗ 1.1</b>	Тендер шалгаруулалтын нэр: <b>Аж ахуй хангамж, ариутгал цэвэрлэгээний материал худалдан авах</b>
<b>ТШЗ 1.1</b>	Тендерийн урилгын дугаар: <b>НТТТ/202401004</b>
<b>ТШЗ 1.2</b>	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багц 1: Засвар, сантехник, цахилгааны материал</b> <b>Багц 2: Цэвэрлэгээний материал</b>
<b>ТШЗ 1.3</b>	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: <b>Дотоодын багц № 3: Аюулгүйн хайрцааг</b>
<b>ТШЗ 1.4</b>	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “ <b>Үгүй</b> ”
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Тухайн байгууллагын өөрийн хөрөнгөөр</b> Нийт төсөвт өртөг: <b>177,439,600 /Нэг зуун далан долоон сая дөрвөн зуун гучин есөн мянга зургаан зуу/</b> <b>Багц 1: 39,914,100 /Гучин есөн сая есөн зуун арван дөрвөн мянга нэг зуу/</b> <b>Багц 2: 113,475,500 /Нэг зуун арван гурван сая дөрвөн зуун далан таван мянга таван зуу/</b> <b>Багц 3: 24,050,000 /Хорин дөрвөн сая тавин мянга/</b>
<b>Б. АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 8.1</b>	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: <b>Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Ж.Нямпүрэв</b> Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чин ван Чагдаржавын гудамж, Нийслэлийн түргэн тусlamжийн төв Утасны дугаар: <b>11-321811, 88297070</b>
<b>ТШЗ 11.1</b>	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “ <b>Үгүй</b> ”
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 12.2</b>	Зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: “ <b>Монгол хэл</b> ”
<b>ТШЗ 15.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: “ <b>Зөвшөөрөхгүй</b> ”
<b>ТШЗ 17.4</b>	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: “ <b>Үгүй</b> ”
<b>ТШЗ 17.6</b>	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: “ <b>Үгүй</b> ”
<b>ТШЗ 18.1</b>	Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “ <b>Шаардахгүй</b> ” Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “ <b>Шаардлагатай</b> ” <ul style="list-style-type: none"> <li>• <b>2023 он. Уг тендерийн батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа /Ариутгал, цэвэрлэгээ, сантехник, цахилгааны материал/ нийлүүлсэн гэрээ болон гэрээ дүгнэсэн акт доод тал нь 1 удаа ирүүлэх.</b></li> </ul> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “<b>Шаардана.</b>”<ul style="list-style-type: none"> <li>• <b>Ачааны машин 1 ширхэг /Бараа зөөх/</b> Тухайн машин нь тухайн байгууллагын юм уу өмчлөгчийн нэр дээр эсвэл гэрээ дуусах хүртэлх хугацаанд түрээсийн гэрээтэй байх. /Бичиг баримтыг хавсаргах/</li> </ul><p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p></p>

	<ul style="list-style-type: none"> <li>Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 оны гүйцэтгэсэн борлуулалтын орлогын хэмжээ нь тус бүр батлагдсан төсвийн 80 хувиас багагүй байх</li> </ul> <p>Оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: “Шаардахгүй”</p>
ТШЗ 18.2	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардахгүй”
ТШЗ 19.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: <b>“Тийм”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Харилцагч банкны мэдэгдэл ирүүлэх /Хугацаа хэтэрсэн зээлгүй талаар дурдсан байх./</li> <li>Монгол Улсын хуулийн дагуу татвар, даатгал, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын, нийгмийн даатгалын тодорхойлолтуудыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд худалдан авалтын цахим системээс өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.</li> <li>2022, 2023 оны жилийн санхүүгийн тайлан /Цахимаар шалгана./</li> <li>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2022, 2023 он</li> <li><b>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай.</b></li> </ul>
ТШЗ 20.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: <b>“Үгүй”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /Гадаад худалдаа/</li> <li>Шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа ирүүлнэ. /Цахимаар/</li> <li>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг ирүүлнэ. /Цахимаар/</li> <li>Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай албан мэдүүлэг ирүүлнэ.</li> <li>Техникийн тодорхойлолтын дагуу шаардлага хангагүй бараа бүтээгдэхүүнийг шинэ, шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнээр солих үүрэг хүлээх тухай тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардахгүй”</li> </ul>
ТШЗ 21.5.	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна” Албан тоотоор мэдэгдэл ирүүлэх.</b>
ТШЗ 21.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: <b>“Тийм” Incoterms 2020, DDP HTTT-ийн авто баазад захиалгын дагуу хүргэж өгөх талаар мэдэгдэл ирүүлэх.</b>
ТШЗ 24.1	<p>Тендерийн баталгааны дүн:</p> <p><b>Багц 2: 567,378 төгрөг /2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал хүчинтэй байх/</b></p>
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
ТШЗ 25.5.	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p><b>Санал болгосон барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох баримт Тендерт оролцогчийн сүүлийн 3 жилийн хугацаанд оролцсон иргэний хэрэг, маргааны талаар шүүхийн архивын байгууллагаас холбогдох дүрэм, журмын хүрээнд гаргасан тодорхойлолт;</b></p>
ТШЗ 26.1.	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p><b>Огноо: 2024 оны 03 дугаар сарын 12-ний өдөр</b></p> <p><b>Цаг: 09 цаг 00 минут</b></p>

<b>ТШЗ 26.2.</b>	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: <b>2024 оны 03 дугаар сарын 12-ний өдөр</b> Цаг: <b>09 цаг 10 минут</b> Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <b>Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чин ван Чагдаржавын гудамж, Нийслэлийн түргэн тусlamжийн төвийн сургалтын танхимд</b>
<b>Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ</b>	
<b>ТШЗ 29.2.</b>	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <b>“Үгүй”</b>
<b>ТШЗ 31.1.</b>	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: <b>Шаардахгүй</b>
<b>ТШЗ 32.1</b>	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: <b>“Ашиглахгүй”</b>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

№	Нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Техникийн тодорхойлолт
<b>Багц 1: Засвар, сантехник, цахилгааны материал</b>				
1	Өнхрүүш /том/	ш	30	Үс унахгүй, шамарч мултрахгүй гартай
2	Өнхрүүш /гар/	ш	5	Урт модон иштэй
3	Өнхрүүш /жижиг/	ш	30	Үс унахгүй, шамарч мултрахгүй, гартай
4	Өнхрүүш /дунд/	ш	30	
5	Өрөм № 6 /бетон /	ш	3	
6	Өрөм № 8 /бетон /	ш	3	
7	Өрөм № 10 /бетон /	ш	2	
8	Өрөм № 12 /бетон /	ш	2	
9	Өрөм № 3 төмөр	ш	2	
10	Өрөм № 4 төмөр	ш	1	
11	Өрөм № 5 төмөр	ш	1	
12	Өрөм № 6 төмөр	ш	1	
13	Өрөм № 7 төмөр	ш	1	
14	Өрөм № 8 төмөр	ш	1	
15	Өрөм № 9 төмөр	ш	1	
16	Өрөм № 10 төмөр	ш	1	
17	Өрөм № 11 төмөр	ш	1	
18	Өрөм № 12 төмөр	ш	1	
19	Багс /том/	ш	30	
20	Багс /дунд/	ш	30	Үс нь өтгөн унахгүй модон иштэй
21	Багс /жижиг/	ш	30	
22	Бахь	ком	1	Хат сайтай, бариул сайн чанарын
23	Булан төмөр	ш	100	Төмөр сайтай ган
24	Бүргэд хаалганы цоож	ком	10	Сайн чанарын төмөр сайтай
25	Бүргэд хаалганы цоожны гол	ш	5	Сайн чанарын төмөр сайтай
26	Зүлгүүр	метр	30	Нарийн ширхэгтэй зузаан
27	Зүлгүүр /дугуй/	ш	100	Нарийн ширхэгтэй зузаан дугуй
28	Зүлгүүр /таваг/	ш	10	Иштэй модон
29	Зүлгүүрийн гар	ш	3	Урт иштэй
30	Замган түгжээ	ш	5	Төмөр сайн, углуурга нь бөх /дунд зэргийн/
31	Замаск	ш	20	1 уутандаа 25 кг цагаан өнгөтэй ,ус сайн шингээдэг
32	Кнаф	уут	3	1 уутандаа 15-20 кг цагаан өнгөтэй чанартай
33	Лагшин шохой	кг	2	Цагаан өнгөтэй сайн чанарын 1кг
34	Будаг /цагаан/	л	10	
35	Будаг /шар/	л	3	
36	Будаг /ногоон/	л	4	
37	Будаг /цэнхэр/	л	5	
38	Будаг шүршдэг	ш	20	Шүршдэг хар өнгөтэй
39	Будаг шингэлэгч	ш	20	500гр будаг гашилгахгүй, харшил өгөхгүй
40	Буузан зүлгүүр	ш	150	Сайн чанарын
41	Нугас /том/	хос	10	

42	Нугас /жижиг/	хос	20	Төмөр сайтай сайн чанарын, даац сайтай
43	Нугас амраагч /тайвшруулагч/	ш	5	Сайн чанарын төмөр сайтай
44	Пигмент /ногоон /	ш	5	
45	Пигмент /шар /	ш	5	Ногоон шар өнгийн 300 гр
46	Плита 30*60	ш	30	30*60 цайвар ногоон өнгөтэй, зузаан
47	Плитаны ир	хайр	5	Ир сайтай төмөр
48	Тасдагчийн ир /том/	хайр	3	Ир сайтай төмөр
49	Тасдагчийн ир /жижиг/	хайр	5	Төмөр сайтай сайн чанарын
50	Силикон	ш	20	Цагаан өнгөтэй сайн чанарын
51	Силикон	ш	20	Өнгөгүй, сайн чанарын
52	Резинэн будаг	ш	2	18л ногоон өнгийн үнэргүй, харшил өгөхгүй, хурдан хатдаг
53	Силиконы буу	ш	2	Гарт эвтэйхэн. Сайн чанарын
54	Төмөр шпатель жижиг	ш	5	
55	Төмөр шпатель 100 мм	ш	5	Модон иштэй төмөр
56	Төмрийн шрүп № 4	хайр	10	
57	Төмрийн шрүп № 3	хайр	10	Резво сайтай,
58	Төмрийн шрүп № 1.8	хайр	5	
59	Точель	ш	5	Төмөр сайтай
60	Тэлэгч 6ф	уут	3	
61	Тэлэгч 8ф	уут	3	Цагаан өнгөтэй сайн чанарын
62	Үдээсний гар буу	ком	1	Төмөр сайтай олон үйлдэлтэй
63	Хөөс шахдаг	ш	10	940гр солонгос хөөстэй дүйцэхүйц сайн чанарын
64	Хөрөөний ир № 12 /модны/	ш	10	
65	Хөрөөний ир № 180 /модны/	ш	2	Шуд төмөр сайтай
66	Хаалганы бариул /модон/	ш	5	Сайн чанарын модон
67	Хар замаск	уут	2	18 кг хар өнгөтэй сайн чанарын
68	Хар лак /шингэн/	л	5	18 кг шингэн сайн чанарын солонгос улсынхтай дүйцэхүйц
69	Хар цаас	ш	10	Наалт чулуу сайтай зузаан
70	Цаасан скоч	ш	30	5 см өргөнтэй цавуулаг сайтай
71	Цаасны хутга	ш	10	Ир сайтай сайн чанарын
72	Цаасны хутганы ир	боод	5	Ир сайтай сайн чанарын
73	Цүү	хос	5	Төмөр сайтай дунд зэргийн
74	Цавуу 107	ш	3	
75	Цавуу 505	ш	3	500 гр Наалт сайтай,
76	Цемент	уут	5	1 уутандаа 20 кг цавуулаг сайтай МАК ийн сайн чанарын
77	Цоож ком /ручиктай /	ком	20	
78	Цоожны гол № 8	ш	10	
79	Цоожны гол №6	ш	10	Төмөр сайтай сайн чанарын
80	Зүүдэг цоож /том/	ш	10	Сайн чанарын төмрөн
81	Зүүдэг цоож /жижиг/	ш	20	Сайн чанарын төмрөн
82	Шингэн хадаас	ш	20	Наалдац сайтай сайн чанарын
83	Шпатель /пивор/	ш	20	Пивор шар циллодон
84	Шпатель /бариултай/	ш	10	Төмөр модон бариултай
85	Шрүп хар № 1.8	хайр	3	
86	Шрүп хар № 2	хайр	3	Резво сайтай, хар төмөр

87	Шрүп хар № 3	хайр	2	
88	Шрүп хар № 4	хайр	2	
89	Шрүп хар № 5	хайр	2	
90	Шрүп хар № 7	хайр	2	
91	Шрүп хар № 8	хайр	2	
92	Шрүп хар № 10	хайр	2	
93	Шар цавуу	ш	10	Сайн наалддаг үнэр багатай 500гр
94	Шат / том/	ш	1	Хөнгөн цагаан сандаг 6 н гишгүүртэй 2.8 м хүртэл сунана
95	Шат /жижиг /	ш	6	Төмөр, 5 гишгүүртэй эвхэгддэг
96	Электрод Р-2.5	хайр	2	2.5 тай нарийн
97	Эмульс /18литр /	л	3	18л -тэй цав цагаан өнгөтэй сайн чанарын
98	Үртэс	уут	400	Хуурай нарийн ширхэгтэй
99	Хайрга	машин	2	0.5 тай
100	Элс	шууд	20	
101	Шилэн хөвөн	боод	50	Сайн чанарын
102	Труба	м	75	32ф сайн чанарын зузаан, өлгүүр /морь/ хийх
103	100 хоолой	ш	6	Зузаан, ирмэг булан эмтрээгүй
104	15 булан PVC	ш	15	Төмөр сайтай, резво сайтай
105	15 заглушка	ш	10	Төмөр сайтай, резво сайтай
106	15 изгон	ш	4	Төмөр сайтай, резво сайтай
107	15 муфт	ш	16	Төмөр сайтай, резво сайтай
108	15 контур	ш	19	Төмөр сайтай, резво сайтай
109	15 хомичик	ш	11	Сайн чанартай боолттой
110	15 эр PVC тройник	ш	8	Төмөр сайтай, резво сайтай дотор хумс сайн
111	15/10 пудрик	ш	10	
112	15/20 пудрик	ш	10	Үзүүр булан эмтрээгүй
113	15/20 эм үзүүр	ш	8	ширэм сайтай дотор талын резво сайтай
114	15 булан /ширмэн/	ш	10	Төмөр сайтай, резво сайтай
115	20 заглушка	ш	6	Төмөр сайтай, резво сайтай
116	20 изгон	ш	18	Төмөр сайтай, резво сайтай
117	20 муфт	ш	20	Төмөр сайтай, резво сайтай
118	20 контур	ш	20	ширэм сайтай дотор талын резво сайтай
119	20 фа	ш	10	Төмөр сайтай, резво сайтай
120	20 тройник	ш	20	Төмөр сайтай, резво сайтай дотор хумс сайн
121	32 хомичик	ш	15	Сайн чанартай боолттой
122	32/25 муфт	ш	10	Дотор резво сайтай
123	32 изгон	ш	10	Төмөр сайтай, резво сайтай
124	40 жийрэг	ш	6	Резво сайтай,
125	50 тройник	ш	10	Төмөр сайтай, резво сайтай дотор хумс сайн
126	50 булан /бохирын/	ш	6	50Ф бохирын булан эмтэрч гэмтээгүй, тослогтой,
127	Парнит 50Ф /сальник/	ш	20	Зөвлөн резинэн сэтрээгүй 50Ф
128	Парнит 89ф /сальник/	ш	20	Зөвлөн резинэн сэтрээгүй 89Ф
129	Парнит 100ф /сальник/	ш	20	зөвлөн сэтрээгүй
130	Пранцус /чангалаагч/	ш	5	резво сайтай, төмөр сайтай чанартай

131	Бохирын грамушик резин	ш	10	Цагаан өнгийн резин зөөлөн
132	Бохирын бамбар	ш	5	Цоороогүй резин зөөлөн
133	Бохирын трасс	м	50	Диаметр 1.5 см хатуу
134	Бохирын хоолой	ш	5	Зузаан, ирмэг булан эмтэрээгүй
135	Шээлтүүр мэдрэгчтэй	ш	5	Мэдрэгч сайтай
136	Шээлтүүр сифон	ш	50	Резин жийргэвч сэтрээгүй
137	Сифон 2той	ш	20	Саарал өнгийн пивор зузаан 2-той резин жииргэвч сэтрээгүй
138	Сифон холбогч	ш	10	Резин жииргэвч сэтрээгүй
139	Уян 60см 10*15	хос	20	Сайн чанарын резва сайтай
140	Уян 60см 15*15	хос	20	
141	Уян 80см 10*15	хос	20	
142	Уян 80см 15*15	хос	20	
143	Холигч Y /гал тогооны уян /	ком	20	Ледемтэй дүйцэхүйц сайн чанарын тэмрөн Y хэлбэрийн гол тогоонд хэрэглэгдэх уян
144	Холигч Y / хатуу/	ком	10	Ледемтэй дүйцэхүйц сайн чанарын тэмрөн Y хэлбэрийн хэрэглэгдэх
145	Душны холигч	ком	10	Душ холигчтой комоороо Ледемтэй дүйцэхүйц сайн чанарын тэмрөн
146	Душ толгой	ш	10	Сайн чанарын тэмрөн
147	Душ шаланк	ш	10	Сайн чанарын тэмрөн доторх шланк нь хар өнгөтэй
148	Дулааны автомат хувиарлагч	ш	1	захиалах үедээ марк хэмжээ өгнө
149	Дулааны автомат толгой АМВ -25	ш	1	захиалах үедээ марк хэмжээ өгнө
150	Дулааны автомат холбогч	ш	1	захиалах үедээ марк хэмжээ өгнө
151	Автомат 1ф 25 А	ш	5	Сайн чанарын 1ф 25 А
152	Автомат 1ф32А	ш	5	Сайн чанарын 1ф 32 А
153	Автомат 2ф 25 А	ш	5	Сайн чанарын 2ф 25 А
154	Автомат 2ф 32А	ш	5	Сайн чанарын 2ф 32 А
155	Гэрэл 18в	ш	30	Дугуй лед 18в сайн чанарын
156	Лед урт гэрэл 60W	ш	40	Лед гэрэл урт хавтгай нарийн 60W өргөн - 7.5 см
157	Далд разетка	ш	20	Сайн чанарын солонгостой дүйцэхүйц
158	Далд унтраалга	ш	20	1 дарагчтай сайн чанарын солонгостой дүйцэхүйц
159	Далд кроп	ш	20	Сайн чанарын пивор
160	Утас далдлагч 2той	ш	40	Сайн чанарын пивор
161	Утас далдлагч 6той	ш	15	Сайн чанарын пивор
162	Ил разетка	ш	20	1-тэй сайн чанарын солонгостой дүйцэхүйц
163	Ил унтраалга	ш	20	1-тэй сайн чанарын солонгостой дүйцэхүйц
164	Кабелийн утас КГ -2*4 /зэс/	м	250	Сайн чанарын зэс голтой КГ-2*4
165	Соронзон пускатель 25A	ш	6	Сайн чанарын 25A
166	Цахилгаан дрилл	ш	2	KEN загвартай дүйцэхүйц сайн чанарын, цохилттой
167	Цохилтгүй дрилл	ш	2	KEN загвартай дүйцэхүйц сайн чанарын, цохилтгүй
168	Цахилгааны утас 2*2.5	м	100	Сайн чанарын 2*2*5
169	Автеркны толгой	хайр	2	Сайн чанарын тэмрөн

170	Гагнуурын алх	ш	1	Сайн чанарын
171	Цахилгаан кембриж	ш	5	Сайн чанарын
172	Мужаны багажны цүнх	ш	1	1 мөрөвчтэй ажлын цүнх, элэгдэлд тэсвэртэй материалыар хийгдсэн, Хэмжээ: 46 x 24 x 27.5 см
173	Сүлжээний утас	хайр	1	300м урттай САТ 6 нарийн зэсний агууламжтай
174	Сүлжээний толгой	уут	1	уутандаа 50 ширхэгтэй САТ 6
175	Галын хор	ш	10	4 кг савалгаатай
176	Галын хор	ш	75	1.5 кг савалгаатай
177	Хамгаалалтын дуулга каск	ш	8	Сайн чанарын

**Багц 2: Цэвэрлэгээний материал**

1	Агааржуулагч	ш	150	360 мл анхилуун үнэртэй, хүний биед харшлахгүй нүүрс хүчлийн хлорфтор агуулаагүй байх
2	Алчуур	ш	1,000	Ус чийг сайн авдаг, бөөсрөхгүй,
3	А даавуу	м	800	Урт 70 м, өргөн 50 см ус сайн даадаг
4	Алчуур /3 өнгийн /	ш	500	380мм*380мм бөөсрөхгүй ус чийг сайн авдаг
5	Белизна	ш	450	1 л -тэй цайруулагчтай ариутгах процесс өндөр үнэр бага байх
6	Борооны цув	ш	150	Зузаан ус чийг нэвтрэхгүй
7	Бохирын маск	ш	5	Зузаан агааруужуулах салхивчтай
8	Бохирын уут/хар/	ш	6,000	800*600 хэмжээтэй хог хаягдлын логотой, хар өнгөтэй, зузаан, бариулгүй
9	Бохирын уут /жиж тасалдаг/	ш	100	500*600 хэмжээтэй зузаан, таслагчтай хар өнгөтэй бариулгүй
10	Бохирын уут /том тасалдаг/	ш	100	800*600 зузаан, таслагчтай хар өнгөтэй
11	Бохирын уут /шар/	ш	4,000	800*600 хэмжээтэй, шар өнгөтэй, хог хаягдлын логотой, бариулгүй
12	Бохирын бөглөө гаргагч бодис	ш	60	Үнэргүй, харшил өгөхгүй, бохир сайн задладаг 300 гр
13	Бохирын бөглөө гаргагч хавчаар	ш	20	3 метртэй сайн чанарын тросстой
14	Бүйдан өнгөлөгч	ш	20	350 мл харшил өгөхгүй
15	Бүйдангийн углаа	ш	50	
16	Бээлий /гагнуурын/	ш	5	Галд тэсвэртэй арьсан
17	Ажлын бээлий цагаан	хос	1,000	Ажлын цагаан өнгөтэй зузаан даавуун 5 хуруутай
18	Ажлын бээлий улаан алаптай	хос	3,000	Алга нь 3 давхар улаан будагтай, цагаан ус чийг хэтрүүлэхгүй, хайрахгүй 5 хуруутай
19	Гарын шингэн саван	л	50	5л бактери устгагчтай, гар хуурайшуулахгүй, хүний биед сөрөг нөлөөгүй анхилуун үнэртэй
20	Гишгүүр	ш	40	90*60 хэмжээтэй хээтэй дрожин материалтай, ардаа резинтэй
21	Гишгүүр /дрож/	м	30	Өргөн 1.2 м , урт 30м арзгар , хээтэй , хүйтэнд тэсвэртэй, хальтрахгүй
22	Дэрсэн шүүр	ш	30	Модон иштэй, дэрс сайтай
23	Жавилион	хайр	100	300 ширхэгтэй, ариутгалын бодистой, харшил өгөхгүй

24	Илгэн алчуур	ш	500	Ус сайн даадаг, бөөсрөхгүй, загалтуулахгүй сайн чанартай, цэвэр илгэн алчуур
25	Комет /хуурай/	ш	250	475 гр хуурай ариутгалын, харшил өгөхгүй
26	Комет шингэн	ш	200	700 мл шингэн, ариутгалын харшил өгөхгүй
27	ОО угаагч шингэн	ш	200	500 мл цэнхэр өнгийн бактери устгагчтай шингэн
28	ОО-ын цаас	ш	150	4 давхар 150м урттай, цэцгэн хээтэй, цагаан өнгөтэй усанд уусах чадвартай, таслагчийн хэмжээ 11.5 *9.3
29	Сальфетка /нойтон/	ш	50	1 уутандаа 100 ш гаж нөлөөгүй цагаан өнгөтэй, ус багатай, нээх хэсэг нь пивор тагтай, хүний биед харглахгүй
30	Сальфетка хайрцагтай	ш	50	100 % байгалийн гаралтай, зөвлөн, харглахгүй цагаан өнгийн хуурай, хайрцагтай 200-250 ширхэгтэй
31	Сальфетик хуурай /гал тогооны/	ш	100	200-250 ширхэгтэй зөвлөн цагаан гол тогоонд хэрэглэх зориулалттай хэт нимгэн биш
32	Сойз (хана шалны)	ш	30	Жижиг бариултай үс нь ширүүн
33	Резинэн бээлийн	ш	50	M размер
34	Тос зайлцуулагч	ш	200	1 л тос маш сайн задладаг /EDIKA/ Θөх тостой хүнсний бохир үлдэглүүдийг маш түргэн уусгах
35	Угаалгын нунтаг	гр	200	400 гр утттай, хүйтэн усанд сайн уусдаг, хөөсрөлт сайн хүний биед харглахгүй
36	Угаалгын нунтаг	гр	100	1.8-2.0 кг /Миф /-тай дүйцэхүйц, хүйтэн усанд сайн уусдаг, хөөсрөлт сайн, хүний биед харглахгүй, цайруулагчтай
37	Угаалгын нунтаг	гр	300	800 гр /White/ -тай дүйцэхүйц, хүйтэн усанд сайн уусдаг, хөөсрөлт сайн, хүний биед харглахгүй
38	Хүрз	ш	12	Модон иштэй, төмөр нь хавтгай, сайн чанарын төмрөн
39	Хүрз	ш	12	Модон иштэй, төмөр нь хумбан, сайн чанарын төмрөн
40	Хүрз /цасны/	ш	12	Цас цэвэрлэх кориулалттай модон иштэй пивор зузаан
41	Хивс цэвэрлэгч	ш	20	500 гр анхилуун үнэртэй, толбо арилгагчтай
42	Хогийн шүүр тосгуурт	ком	20	Төмөр иштэй, их бие нь хуванцар, шигүү зөвлөн үстэй сайн чанарын бөх бат, тосгуурандаа үс авагч самтай
43	Хувцас зайлгач	ш	50	1 л анхиулуун үнэртэй
44	Шүүр /том/	ш	10	Модон урт иштэй шүүрний өргөн 90 см, гадна цэвэрлэгээний үс сайн, унахгүй бат бөх байх
45	Шал угаагч /автомат/	ком	10	Дардаг мушигчтай, зузаан пивор, сайн чанарын
46	Шал угаагч шингэн	ш	100	450 гр харшил өгөхгүй сайн хөөсөрдөг тос болон тоос сайн арилгах
47	Шал угаагчийн запас үс	ш	30	Үс унахгүй ус сайн авдаг
48	Шил арчигч шингэн	ш	150	0.5 мл спиртын агууламжтай

49	Шингэн савангийн сав	ш	10	Хуванцар сайн чанарын
50	Эдийн саван	ш	2,500	150 гр-тай цайруулагчтай анхилуун үнэртэй , хүний биед сөрөг нөлөөгүй, усанд уусгалт удаан, толбо сайн арилгах
51	Усны гутал	ш	150	Сайн чанарын резинэн өвдөг хүртэл түрийтэй 38-42 раз
52	Мөс цохигч	ш	20	Төмөр сайтай
53	Духны гэрэл	ш	149	Толгойд угладаг резинтэй, гэрэл нь тод асдаг
54	Гар халаагч	ш	300	Цаасан ууттай, нэг удаагийн
55	Аяга угаагч пролон	ш	250	Сайн чанарын герман улсад үйлдвэрлэсэнтэй дүйцэхүйц, пролон дотроо 6 ш тэй
56	Аяга угаагч шингэн	ш	400	500 гр- тай Fairy-тэй дүйцэхүйц, харшил өгөхгүй, анхиулуун үнэртэй, сайн хөөсөрдөг
57	Мөнгөлөг цаас /хүнсний/	ш	50	Сайн чанарын зузаан
58	Хүнсний скоч	ш	72	Өргөн 40 см, сайн чанарын
59	Хүнсний тор	боод	24	Сайн чанарын зузаан цагаан өнгөтэй
60	Хүнсний уут /жижиг/	боод	576	1 боодолдоо 100ш, хүнсний тунгалаг өнгөтэй бариултай
61	Хүнсний бээлий	ком	288	Хайрцагандаа 20 ширхэгтэй
62	Цайны аяга	ш	250	Хагардаггүй, шаазан материалтай, хүнсний зориулалттай материалаар хийгдсэн, халуунд тэсвэртэй, ариутгаж болохуйц
63	Таваг /1-р хоолны/	ш	250	Хагардаггүй, шаазан материалтай, хүнсний зориулалттай материалаар хийгдсэн, халуунд тэсвэртэй, ариутгаж болохуйц
64	Таваг /2-р хоолны/	ш	250	Хагардаггүй, шаазан материалтай, хүнсний зориулалттай материалаар хийгдсэн, халуунд тэсвэртэй, ариутгаж болохуйц
65	Халбага	ш	250	Ган төмөр материалтай
66	Сэрээ	ш	250	Ган төмөр материалтай
67	Өндөг чанагч	ш	5	2-3 давхар өндөг чанагч , Уураар чанана, Нэг давхартай 5-7 өндөг ордог байх
68	Төмөр зүлгүүр	ш	100	Герман улсын GUT @GUSTING брэндийн төмөр зүлгүүртэй дүйцэхүйц
69	Газын плитка	ш	5	2 ширэмтэй, гал тогоонд хэрэглэх, том баллон холбогддог
	<b>ДҮН</b>			
<b>Багц 3: Аюулгүйн хайрцаг /Дотоод багц/</b>				
1	Аюулгүйн хайрцаг	ш	13,000	Хэмжээ: 3 литр багтаамжтай Материал: зузаан кардонон цаасан, Зориулалт: Хэрэглэсэн зүү, тариур хийх

### Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

## Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

### Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр: .....

№	Захиалгчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалгчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1			
2			
3			
...			

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]

## Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө ]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа		
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)	7
1	2	3	4	5	6		
1	Аж ахуй хангамж, ариутгал цэвэрлэгээний материал			НТТ	2024.04.09-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]	

#### IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна ТШЗ-ны 35.1.6-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

**“Ашиглахгүй**

## V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

- Маягт 1. Тендер илгээх маягт
- Маягт 2. Барааны үнийн задаргаа
- Маягт 3. Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл
- Маягт 4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл
- Маягт 5. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл
- Маягт 6. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

**[Захиалагч байгууллагын нэр]-д**

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
  - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.<sup>1</sup>
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

**[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,  
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,  
албан тушаал, гарын үсэг,  
байгууллагын тамга, тэмдэг]:**

**Хаяг:**

<sup>1</sup> Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

Маягт 2      **Барааны үнийн задаргаа**

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс <sup>2</sup>	Тоо хэмжээ	Хэмжи х нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх <sup>3</sup>
1										Тийм/Үгүй
2										
...										
	Тендерийн нийт үнэ									

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:

<sup>2</sup> ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

<sup>3</sup> Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3

**Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 4

**Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 5

### Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 6

**Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	<b>Нууцалсан баримт бичиг, мэдээлэл</b>	<b>Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл</b>
1.		
2.		
3.		
4.		
5.		

## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
  - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
  - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
  - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
  - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
  - 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
  - 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
  - 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
  - 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн догоолдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
  - 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас догоолдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;

- 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
- 1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;
- 1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
- Гэрээний тайлбар
- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
- 1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.
  - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
  - 1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлахад бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
  - 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
  - 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.
- ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ**
- Бараа нийлүүлэх
- 2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан

	хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
	2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
	2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
	2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
Бараа нийлүүлэх газар	2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.
	2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
	2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгэгүй;
	2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.
Барааг хүлээлгэн өгөх	2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
Барааны гарал үүслийн улс	2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.
Баглаа боодол	2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
	2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
	2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.
	2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
	2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.

- |   |   |
|---|---|
| <p>Худалдааны нөхцөл</p> <p>Гүйцэтгэлийн баталгаа</p> <p>Барааг хүлээн авах</p> <p>Шалгалт, туршилт</p> | <p>2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.</p> <p>2.16 Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.</p> <p>2.17 Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.</p> <p>2.18 ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.</p> <p>2.19 Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.</p> <p>2.20 Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>2.20.1 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;</li> <li>2.20.2 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</li> <li>2.20.3 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.</li> </ul> <p>2.21 Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.</p> <p>2.22 ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.</p> <p>2.23 Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.</p> <p><b>ГУРАВ. ЗАХИАЛАГЧ</b></p> <p>3.1 Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.</p> <p>3.2 Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй.</p> |
|---|---|

	<p>Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.</p> <p>3.3 Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.</p> <p>3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.</p> <p>3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.</p> <p>3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.</p>
Гэрээний үнэ	<p>3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.</p>
Төлбөр төлөх	<p>3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.</p> <p>3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.</p> <p>3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p> <p>3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p>
Захиалагчийн хүлээх эрсдэл	<p><b>ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА</b></p> <p>4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;</p>

- 4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаarahгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.
- Даатгал
- 4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.
- Доголдол
- 4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.
- 4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.
- 4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.
- 4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.
- 4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.
- 4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
- Чанарын баталгаа
- 4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.
- 4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.
- 4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.
- 4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- 4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.

- |  |   |
|--|---|
| <p>Алданги</p>   | <p>4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> <p>4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.</p> <p>4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.</p> <p>4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p> |
| <p>Оюуны өмчийн эрх зөрчих</p>                                       | <p>4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p>   |
| <p>Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал</p> | <p>4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.</p> <p>4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл</p>  |
| <p>Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа</p>                             |   |

Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

#### **ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ**

Гэрээнээс татгалзах,  
гэрээг цуцлах үндэслэл

5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:

5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;

5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;

5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.

5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.

5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, залилах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.

5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.

5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.

5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

#### **ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**

Төлөөлөгч

6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.

6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Туслан гүйцэтгэгч	6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй. 6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.
Нууцлал	6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй. 6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.
Мэдэгдэл	6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ. 6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ. 6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ. 6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно: 6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн; 6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах	6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ. 6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна. 6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна: 6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан; 6.15.2. үнийн тохируулга хийсэн.

Маргаан шийдвэрлэх

- 6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
- 6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцэх замаар шийдвэрлэнэ.
- 6.19. Талууд зөвшилцэн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.5.</b>	Бараа нийлүүлэх газар: <b>Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Нийслэлийн түргэн тусlamжийн төвийн Автобааз</b>
<b>ГЕН 2.6.</b>	Бараа нийлүүлэх хугацаа: <b>2024.04.09-2024.12.31</b> Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа: [огноо бичих эсхүл нийлүүлэлтийн хуваарь байгаа бол түүнийг ишлэх]
<b>ГЕН 2.10.</b>	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: <b>Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Нийслэлийн түргэн тусlamжийн төвийн Авто бааз</b> Бараанд холбогдох баримт бичиг: Цахим нэхэмжлэх, зарлагын баримтын хамт хүлээлгэн өгөх Угсралт, суурилуулах: <b>байхгүй</b>
<b>ГЕН 2.14.</b>	Баглаа, боодол: [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөл, шаардлагыг тодорхой бичих.] [Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг бичих] Баглаа, боодлын шаардлага: <b>Жишээ нь:</b> [Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна гэх мэт]
<b>ГЕН 2.17.</b>	Худалдааны нөхцөл: “Тийм” Incoterms 2020, DDP, Ulaanbaatar, <b>Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, НТТТ-ийн Авто бааз</b>
<b>ГЕН 3.8.</b>	Үнийн тохируулга хийх аргачлал: <b>Үнэ тохируулахгүй тогтмол байна.</b>
<b>ГЕН 3.9.</b>	Төлбөр төлөх хугацаа: [он, сар, өдөр] Төлбөрийг хэсэгчилсэн төлөх тохиолдолд төлбөр төлөх үе шатны хугацаа: [он, сар, өдөр]
<b>ГЕН 4.2.</b>	Даатгал: <b>Шаардахгүй.</b>
<b>ГЕН 4.10.</b>	Баталгаат хугацаа: <b>Чанарын шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүнийг ажлын 3 хоногт солих.</b>
<b>ГЕН 4.11</b>	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: <b>шаардахгүй</b>
<b>ГЕН 4.17.</b>	Нийлүүлэгчийн төлөх <b>алданги:</b> Алданги тооцох эсэх: “Тийм” Алдангийн хувь: гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хоног тутамд <b>0.1 хувиар тооцох.</b>
<b>ГЕН 4.18.</b>	Захиалагчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “Тийм” Алдангийн хувь: <b>0</b>

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.  
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэрийг бичих] (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч [Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 3.6. Техникийн тодорхойлолт;
  - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:
  - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024.02.16**

Тендер шалгаруулалтын төрөл: Бараа

Тендер шалгаруулалтын нэр: **Аж ахуй хангамж, ариутгал цэвэрлэгний материал худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар: **HTTT/202401004**

Нийт төсөвт өртөг: **177,439,600**

Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

- Нийслэлийн түргэн тусlamжийн төв** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: “**Тийм**”  
**Багц 1: Засвар, сантехник, цахилгааны материал**  
**Багц 2: Цэвэрлэгээний материал**  
**Дотоодын багц № 3: Аюулгүйн хайрцааг**
- Тендерийг **2024 оны 03 дугаар 12-ний өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 03 дугаар сарын 12-ний өдрийн, 09 цаг 10 минутад** нээнэ.
- Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: “**Зөвшөөрөхгүй**”
- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: “**Эрхгүй**”
- Тендер нь түүнийг нээнээс хойш ажлын 30 өдрийн хугацаанд хүчинтэй байна.
- Тендерийн баталгаа шаардах эсэх: “**Тийм**”  
**Баталгааны дүн: Багц 2 – 567,378 төгрөг**
- Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “**Үгүй**”
- Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: “**Үгүй**”
- Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

### ЗАХИАЛАГЧИЙН ХАЯГ:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чин ван  
Чагдаржавын гудамж, HTTT-ийн төв байр  
Утас: 11-321811, 88297070